



БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ТОГТООЛ

1990 оны бурдуг  
сарын 7 өдөр

дугаар 120

Улаанбаатар  
хот

Хот тохижуулах байгууллагуу-  
дын удирдлага, зохион бай-  
гуулалтын тухай

Хот тохижилтын бодлогыг төвлөрүүлэн явуулах, тохижилтын ажлын уялдаа холбоо, арга технологийг боловсронгуй болгох, шат дамжлагыг багасгаж, ажлын чанарыг дээшлүүлэхтэй холбогдуулан Хот тохижуулах байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын бүтэцэд еөрчлөлт оруулах зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хот тохижуулах газрыг 1990 оны 7 дугаар сарын I-нээс эхлэн Хот тохижилтыг удирдах газар болгон өргөтгөж, хотын хурлын байгууллагын нэрийн өмнөөс салбарын бодлогыг эрхлэн явуулах үүрэгтэйгээр зохион байгуулсугай.

2. Хот тохижилтыг удирдах газрын аппаратын 1990-1995 онд тогтвортой мөрдөх сарын цалингийн санг 19,0 мянган төгрөгөөр баталсугай.

3. Хотын нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, эд аж ахуйг хамгаалах ажлыг хариуцах үүрэг бүхий Зам талбайн үйлчилгээний трестийг Хот тохижилтыг удирдах газрын харьяалалд 1990 оны 7 дугаар сарын I-нээс эхлэн байгуулж ажиллуулсугай.

4. Хот тохижуулах байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтыг еөрчилж байгаатай холбогдуулан Улаанбаатар хотын районы Хот тохижуулах конторуудыг 1990 оны 7 дугаар сарын I-нээс эхлэн татан буулгахын хамт нийслэлийн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаандад тус бүр нэг байцаагчийг цалингийн сангийн хамт шилжүүлж өгөхийг Хот тохижилтыг удирдах газар /н.Эрдэнэ-Очир/-т даалгасугай.

2.

5.Багануур, Налайхын районын хот тохижуулах конторуунг  
Хот тохижилтыг удирдах газарт ~~хамгааралгүйгээр тус тусын райо-  
нын АДХ-ын гүйцэтгэх захиргаадад шууд харьяалуулсугай.~~



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

Л.ЭНЭБИШ

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
БИЙГИЙН ДАРГА

Д.АЛИА